



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: *ДОА-2021/76/СТА-ТШЗ*

Цахим хуудас: www.audit.mn

Чойбалсан хот

2021 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга

бөгөөд тэргүүлэх аудитор: Б.Болортуул

Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер: И.Сэмжидмаа

Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор: М.Ухаанбилэг

Утас: 7058-4207, Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ТШЗ	Төсвийн шууд захирагч
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ДОА	Дорнод аймаг
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн



Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт.....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	3
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	3
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	3
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	3
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	3
3. Аудитын тайлан.....	4
3.1. Ерөнхий зүйл.....	4
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	4
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	4
3.4. Материаллаг байдал.....	5
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	5
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт.....	7
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	8
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	8
3.9. Аудитын илрүүлэлт.....	9
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	9
Аудитын зөвлөмж.....	10
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	10
4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт.....	12



1.Хараат бус аудиторын дүгнэлт

Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1.Хараат бус аудиторын дүгнэлт



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг
ЗДП-ын II байр, Утас/Факс: 7058-4203

Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн захирал
М.НАРАНЖАРГАЛ ТАНАА

2021.02.24 № 222

танай _____ -ны № _____ -Т

Г АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ Г

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Хэрлэн сумын 8 дугаар сургууль 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтээр 96.0 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцаж байна.

2021.02.24 ТШЗ 3



Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Б.БОЛОРТУУЛ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	330,102,449.60	357,456,172.83
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	00.00	00.00
33	АВЛАГА	00.00	2,508,196.43
335	Бусад авлага	00.00	2,508,196.43
3351	Байгууллагаас авах авлага	00.00	2,508,196.43
35	БАРАА МАТЕРИАЛ	330,102,449.60	354,947,976.40
351	Түүхий эд материал	97,323,270.84	99,293,611.46
35110	Тусгай зориулалттай материал	96,540,799.84	99,282,611.46
35130	Эм боох материал	782,471.00	11,000.00
354	Хангамжийн материал	232,779,178.76	255,654,364.94
35410	Бичиг хэргийн материал	60,000.00	00.00
35420	Аж ахуйн материал	120,000.00	953,000.00
35470	Бусад хангамжийн материал	232,599,178.76	254,701,364.94
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,550,381,596.23	4,536,850,313.64
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,550,381,596.23	4,536,850,313.64
392	Биет хөрөнгө	4,103,043,521.36	4,090,031,138.81
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,079,982,518.44	4,122,596,948.44
39202	Хуримтлагдсан элэгдэл	-149,096,968.28	-242,437,076.60
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	282,072,695.08	285,756,140.43
39206	Хуримтлагдсан элэгдэл	-239,433,901.08	-258,621,354.45
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	145,347,831.79	183,036,477.26
39208	Хуримтлагдсан элэгдэл	-101,224,039.63	-112,877,324.08
39214	Бусад үндсэн хөрөнгө	85,176,854.00	116,307,989.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-819,786.96	-4,768,979.19
39217	Ном	1,038,318.00	1,038,318.00
393	Биет бус хөрөнгө	447,338,074.87	446,819,174.83
39301	Програм хангамж	9,499,420.00	9,499,420.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-8,536,345.13	-9,055,245.17
39303	Бусад биет бус хөрөнгө	446,375,000.00	446,375,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,880,484,045.83	4,894,306,486.47
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	126,972.00	2,508,196.43
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	126,972.00	2,508,196.43
413	Өглөг	126,972.00	2,508,196.43
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	126,972.00	00.00
4136	Бусад өглөг	00.00	2,508,196.43
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	2,508,196.43
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,880,357,073.83	4,891,798,290.04
51	Засгийн газрын хувь оролцоо	4,880,357,073.83	4,891,798,290.04
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,441,984,414.04	1,441,984,414.04
51101	Өмч: - төрийн	1,441,984,414.04	1,441,984,414.04
512	Хуримтлагдсан үр дүн	1,262,470,883.65	1,273,993,470.31
51210	Өмнөх үеийн үр дүн	1,262,470,883.65	1,262,552,254.10
51220	Тайланг үеийн үр дүн	00.00	11,441,216.21
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,175,901,776.14	2,175,820,405.69
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,880,484,045.83	4,894,306,486.47



**Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (1)	1,600,107,363.14	2,007,080,031.87
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	463,267,263.14	135,808,131.87
120	Нийтлэг татварын бус орлого	458,867,263.14	135,808,131.87
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	458,867,263.14	135,808,131.87
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	458,867,263.14	135,808,131.87
121	Хөрөнгийн орлого	4,400,000.00	00.00
121001	Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	4,400,000.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	45,391,200.00	63,367,200.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлдгээс санхүүжих	1,091,448,900.00	1,807,904,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,047,500.00	6,815,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	4,800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,500,000.00	1,640,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	547,500.00	375,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	43,343,700.00	56,552,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	43,343,700.00	56,552,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,213,692,002.02	1,995,638,815.66
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,213,692,002.02	1,995,638,815.66
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,170,400,949.02	1,817,017,641.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	866,092,371.79	1,422,962,719.66
210101	Үндсэн цалин	661,082,686.79	911,008,392.66
210102	Нэмэгдэл	128,164,900.00	398,593,264.00
210104	Урамшуулал	76,844,785.00	113,361,063.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	86,511,384.71	177,685,416.40
210201	Тэтгэврийн даатгал	53,866,944.49	122,887,361.76
210202	Тэтгэмжийн даатгал	6,765,336.45	12,152,308.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	8,456,670.71	13,394,129.56
210204	Ажилгүйдлийн даатгал	1,583,857.50	2,657,994.68
210205	Эрүүл мэндийн даатгал	15,838,575.56	26,593,622.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	34,950,616.00	49,774,703.00
210301	Гэрэл, цахилгаан	9,481,792.00	9,371,065.00
210302	Түлш, халаалт	20,472,467.00	33,319,770.00
210303	Цэвэр, бохир ус	4,996,357.00	7,083,868.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,573,034.00	12,849,693.00
210401	Бичиг хэрэг	1,449,430.00	5,993,915.00
210402	Тэвэр, шатахуун	284,700.00	1,499,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,482,564.00	1,345,770.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	321,750.00	829,550.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,034,590.00	3,181,158.00
2105	Нормативт зардал	00.00	1,420,771.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэргэсэл	00.00	782,471.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	638,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	415,900.00	10,178,780.00
210604	Урсгал засвар	415,900.00	10,178,780.00
2107	Томилголт, зочны зардал	392,000.00	200,000.00
210702	Догоод албан томилолт	392,000.00	200,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	485,000.00	1,190,270.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	485,000.00	950,270.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	174,980,642.52	140,755,288.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,910,000.00	1,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,226,833.00	5,780,344.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	169,843,809.52	133,474,944.66
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,291,053.00	178,621,173.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	43,291,053.00	43,295,508.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	43,291,053.00	42,298,508.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	997,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	00.00	135,325,665.94
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	135,325,665.94
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	386,415,361.12	11,441,216.21
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	386,415,361.12	11,441,216.21



2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,545,677,220.00	1,871,271,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,545,677,220.00	1,871,271,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,442,726,100.00	1,807,904,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	36,107,420.00	6,815,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	00.00	4,800,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15,102,400.00	1,640,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21,005,020.00	375,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	66,843,700.00	56,552,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	66,843,700.00	56,552,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,545,677,220.00	1,871,271,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,545,677,220.00	1,871,271,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,469,295,432.76	1,692,650,726.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,198,029,212.13	1,423,089,691.66
210101	Үндсэн цалин	884,426,412.13	911,135,364.66
210102	Нэмэгдэл	185,867,600.00	398,593,264.00
210104	Урамшуулал	127,735,200.00	113,361,063.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	149,397,617.63	177,685,416.40
210201	Тэтгэврийн даатгал	103,190,234.32	122,887,361.76
210202	Тэтгэмжийн даатгал	10,029,125.09	12,152,308.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	11,341,931.51	13,394,129.56
210204	Ажилгүйдлийн даатгал	2,257,893.29	2,657,994.68
210205	Эрүүл мэндийн даатгал	22,578,433.42	26,593,622.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	59,021,305.00	49,774,703.00
210301	Гэрэл, цахилгаан	14,957,882.00	9,371,065.00
210302	Тулш, халаалт	34,211,940.00	33,319,770.00
210303	Цэвэр, бохир ус	9,851,483.00	7,083,868.00
2104	Хангамж, бараа материалын зардал	27,957,556.00	18,286,045.00
210401	Бичиг хэрэг	1,568,400.00	2,035,265.00
210402	Тээвэр, шатахуун	684,700.00	1,499,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,012,426.00	1,289,000.00
210404	Ном, хэвлэл	882,900.00	948,388.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	591,850.00	1,912,694.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	19,217,280.00	10,601,398.00
2105	Нормативт зардал	2,215,000.00	1,424,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	125,000.00	237,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,090,000.00	1,187,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,751,822.00	9,544,700.00
210604	Урсгал засвар	7,751,822.00	9,544,700.00
2107	Томилолт, зочны зардал	810,500.00	200,000.00
210702	Дотоод албан томилолт	810,500.00	200,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	787,900.00	1,192,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	787,900.00	952,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	23,324,520.00	11,453,370.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,150,000.00	1,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	19,174,520.00	9,953,370.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	76,381,787.24	178,621,173.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	73,190,900.00	43,295,508.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	73,190,900.00	42,298,508.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	997,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	3,190,887.24	135,325,665.94
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,190,887.24	135,325,665.94
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00



2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,441,984,414.04	2,179,766,016.38	906,600,266.91	00.00	4,528,350,697.33
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	3,864,240.24	00.00	3,864,240.24
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,441,984,414.04	2,179,766,016.38	910,464,507.15	00.00	4,532,214,937.57
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	386,415,361.12	00.00	386,415,361.12
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,441,984,414.04	2,175,901,776.14	1,262,470,883.65	00.00	4,880,357,073.83
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,441,984,414.04	2,175,901,776.14	1,262,470,883.65	00.00	4,880,357,073.83
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	81,370.45	00.00	81,370.45
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,441,984,414.04	2,175,901,776.14	1,262,552,254.10	00.00	4,880,438,444.28
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-81,370.45	00.00	00.00	-81,370.45
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	11,441,216.21	00.00	11,441,216.21
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,441,984,414.04	2,175,820,405.69	1,273,993,470.31	00.00	4,891,798,290.04



2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,872,788,900.00	1,864,456,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,872,788,900.00	1,864,456,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,809,038,400.00	1,685,835,726.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,530,613,900.00	1,423,089,691.66
210101	Үндсэн цалин	929,096,600.00	911,135,364.66
210102	Нэмэгдэл	473,782,100.00	398,593,264.00
210104	Урамшуулал	127,735,200.00	113,361,063.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	191,326,700.00	177,685,416.40
210201	Тэтгэврийн даатгал	130,102,200.00	122,887,361.76
210202	Тэтгэмжийн даатгал	15,306,100.00	12,152,308.30
210203	ҮОМШӨ-ний даатгал	12,244,900.00	13,394,129.56
210204	Ажилгүйдлийн даатгал	3,061,200.00	2,657,994.68
210205	Эрүүл мэндийн даатгал	30,612,300.00	26,593,622.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,807,500.00	49,774,703.00
210301	Гэрэл, цахилгаан	11,347,300.00	9,371,065.00
210302	Түлш, халаалт	33,296,500.00	33,319,770.00
210303	Цэвэр, бохир ус	7,163,700.00	7,083,868.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,153,800.00	18,151,045.00
210401	Бичиг хэрэг	1,900,400.00	1,900,265.00
210402	Тээвэр, шатахуун	1,500,000.00	1,499,300.00
210403	Шуудан, холбоо, ингернэгийн төлбөр	1,289,000.00	1,289,000.00
210404	Ном, хэвлэл	950,200.00	948,388.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,912,700.00	1,912,694.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,601,500.00	10,601,398.00
2105	Нормативт зардал	1,424,800.00	1,424,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	237,000.00	237,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,187,800.00	1,187,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,744,700.00	4,744,700.00
210604	Урсгал засвар	4,744,700.00	4,744,700.00
2107	Томилолт, зочны зардал	200,000.00	200,000.00
210702	Дотоод албан томилолт	200,000.00	200,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	952,700.00	952,700.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	712,700.00	712,700.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	981,430.00	981,337.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,000.00	1,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,314,300.00	8,313,370.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	637,505,000.00	178,621,173.94
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	00.00	135,325,665.94
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	00.00	135,325,665.94
2132	Бусад урсгал шилжүүлэг	63,750,500.00	43,295,508.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	62,750,500.00	42,298,508.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	997,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,872,788,900.00	1,864,456,900.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,816,236,700.00	1,807,904,700.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,816,236,700.00	1,807,904,700.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	56,552,200.00	56,552,200.00
132001	Орон нутгийн төсвөөс	56,552,200.00	56,552,200.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	00.00	00.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	00.00	00.00
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	00.00	00.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	120.00	120.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	97.00	97.00
620003	Үйлчлэх ажилтан	22.00	22.00
620004	Гэрээт ажилтан	00.00	00.00



2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	36107420.00	6,815,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	36107420.00	6,815,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	36107420.00	6,815,000.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	8425136.00	00.00
210101	Үндсэн цалин	8425136.00	00.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1053142.00	00.00
210201	Тэтгэврийн даатгал	1053142.00	00.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13988400.00	135,000.00
210401	Бичиг хэрэг	247500.00	135,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13740900.00	00.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2751822.00	4,800,000.00
210604	Урсгал засвар	2751822.00	4,800,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		240,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		240,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9888920.00	1,640,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9888920.00	1,640,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	36107420.00	6,815,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	36107420.00	6,815,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	15102400.00	6,440,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	21005020.00	375,000.00
131106	Төсвийн урамшуулал		00.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		



3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн дүгнэлтийг захирал М.Наранжаргал танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 17-ноос 2021 оны 02 дугаар сарын 22-ны хооронд Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор М.Ухаанбилэг хариуцаж хэрэгжүүлэв.

Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 06 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ.

- Ерөнхий боловсрол олгох

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Боловсрол, соёл, урлагийн газрын хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс 2020 онд Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит, хяналт хийгдээгүй байна.

Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.



Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг өмнөх жилийн эцсийн үр дүнгийн тайлангийн зардлын 1,231,692,0 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 24,273.8 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд тайлант оны үр дүнгийн тайлангийн зардлын 1,995,638.8 мянган төгрөгөөс 2 хувиар тооцон 39,912.7 мянган төгрөг болгон материаллаг байдлыг өөрчлөв.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,314.2 мянган төгрөгөөр буюу 0.2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан биет бус хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	-
Авлага	00.00	2,508,196.43	2,508,196.43
Урьдчилгаа	0	0	-
Бараа материал	330,102,449.60	354,947,976.40	24,845,526.80
Үндсэн хөрөнгө	4,550,381,596.23	4,536,850,313.64	(13,531,282.59)
Хуримтлагдсан элэгдэл	-499,111,041.08	-627,759,979.49	(128,648,938.41)
Нийт хөрөнгө	4,880,484,045.83	4,894,306,486.47	13,822,440.64
Өр төлбөр	126,972.00	2,508,196.43	2,381,224.43
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,880,357,073.83	4,891,798,290.04	11,441,216.21
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,880,484,045.83	4,894,306,486.47	13,822,440.64

Авлагын дансны үлдэгдэл нь ХБИ-ээс суутгасан дүнгээр үлдэгдэлтэй гарсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 354,947.9 мянган төгрөг болж 24,845.5 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан материалын дүнгээр өссөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,536,850.3 мянган төгрөг болж 13,531.2 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй шилжүүлэн авсан хөрөнгөтэй холбоотой байна.

Өр төлбөрийн дансны үлдэгдэл нь 2,508.2 мянган төгрөг нь ХБИ-ээс ХХОАТ суутгасантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,891,798.3 мянган төгрөг болж 11,441.2 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд нэмэгдсэн хөрөнгийн дүнгээр өссөн байна.

2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 406,972.6 мянган төгрөгөөр буюу 25.4 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 716,455.8 мянган төгрөгийн орлого байна. Энэ нь тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 781,946.8 мянган төгрөгөөр буюу 64.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн цалинг хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал байна.



3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,864,456.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,864,456.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,864,456.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн үйл ажиллагааг санхүүжүүлэх 1,816,236.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 56,552.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,807,904.7 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 56,552.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,864,456.9 мянган төгрөгийг зарцуулж 135,325.6 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,864,546.9 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ЗДТГ-аас 4800,0 мянган төгрөгийг сургуулийн хойд замын өргөтгөлтэй холбоотой хашаа татах, мод бут суулгах санхүүжилт, БСУГ-аас эх орон үзлийг төлөвшүүлэх төслийн санхүүжилт 1640.0 мянган төгрөг, спорт заалны түрээсийн орлого 375.0 мянган төгрөгийн орлого авсан.

Шатахуун болон материалын зардалд зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих нийт 149 мэдээллээс хугацаа хоцроосон болон байршуулаагүй мэдээлэл байхгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 50.2 сая төгрөгийн зөрчилд зөрчилд 1 төлбөрийн акт, 1 зөвлөмж, 2 албан шаардлага өгсөн байна. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/



Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	335.5	1	335.5	-	-	-
Албан шаардлага	2	48,481.3	1	48,481.3			
Төлбөрийн акт	1	1,415.2	1	1,415.2			
Нийт дүн	4	50,232.0	4	50,232.0			

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 2,508.2 мянган төгрөгийн зөрчил илрүүлж 1 албан шаардлага хүргүүлээ.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 2,508.2 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илрүүлж 1 албан шаардлага бичив. Үүнд:

1. Хөгжлийн бэрхшээлтэй, групптэй 2 ажилтны цалингаас 2,508.2 мянган төгрөгийн ХХОАТ суутган авсан байна. Энэ нь Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 22 дугаар зүйлийн “22.1.2 хөгжлийн бэрхшээлтэй хувь хүний орлого;”, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн “18.1.1 хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулж байгаа иргэн, хуулийн этгээдийг хууль тогтоомжийн дагуу татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд хамруулах, тохирох хэрэглэгдэхүүн бүхий ажлын байр бий болгохыг урамшуулах;” гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар зөвлөмж бичигдээгүй.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Анхааралдаа авч үзэх шаардлагатай асуудал байхгүй гэж үзлээ.

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			ДОА-2021/74/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Хэрлэн сумын 8 дугаар сургууль		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр



Хэрлэн сумын 8 дугаар сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

	1	2	3	4	5
1	Хөгжлийн бэрхшээлтэй иргэнээс ХХОАТ суутгаж ажилласан	2,508.2	Албан шаардлага	Захирал, нягтлан бодогч	М.Наранжаргал , Б.Энхбаяр
	ДҮН	2,508.2			